



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2021 оны 04 сарын 12 өдөр

Дугаар 1/180

Арвайхээр

Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн
зөвлөлийг шинэчлэн байгуулах тухай

Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.1.7, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн Үндэсний хорооны 2015 оны 06 дугаар сарын 17-ны өдрийн “Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн салбар хороо, аймаг, нийслэл, дүүргийн зөвлөлийн дүрэм батлах тухай” 04 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн зөвлөлийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Дарга: Аймгийн Засаг даргын орлогч

Гишүүд: Аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн
Хүн ам зүй, хөдөлмөр нийгмийн хамгааллын салбарын бодлого
зохицуулалт хариуцсан мэргэжилтэн
Аймгийн Засаг даргын дэргэдэх Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний
газрын Хөдөлмөр эрхлэлтийн хэлтсийн дарга
Аймгийн Цагдаагийн газрын Нийтийн хэв журам хамгаалах тасгийн
дарга
Аймгийн Засаг даргын дэргэдэх Нийгмийн даатгалын хэлтсийн
Үйлчилгээний тасгийн дарга
Аймгийн Засаг даргын дэргэдэх Эрүүл мэндийн газрын Удирдлага
төлөвлөлтийн хэлтсийн эмнэлгийн тоног төхөөрөмж
хариуцсан мэргэжилтэн
Аймгийн Засаг даргын дэргэдэх Мэргэжлийн хяналтын газрын
Хөдөлмөрийн хяналтын улсын байцаагч
Аймгийн Үйлдвэрчний эвлэлийн холбооны дарга
Аймгийн Ажил олгогч эздийн холбооны дарга
Өвөрхангай аймаг дахь Политехник коллежийн Хөдөлмөрийн
аюулгүй байдал, эрүүл ахуйн багш

Нарийн бичгийн дарга: Аймгийн Засаг даргын дэргэдэх Хөдөлмөр, халамжийн
үйлчилгээний газрын Хөдөлмөрийн харилцаа, хөдөлмөрийн
аюулгүй байдал, эрүүл ахуйн асуудал хариуцсан мэргэжилтэн


2.Хууль тогтоомжийн хүрээнд, орон нутгийн төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгжүүдтэй хамтран ажиллаж, нэгдсэн удирдлагаар хангаж, үйл ажиллагааны төлөвлөлтийг хийж, хэрэгжилтийг ханган, хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч бөгөөд Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн зөвлөлд даалгасугай.

011100392

2.

3. Дээрх захирамж гарсантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2017 оны 05 дугаар сарын 26-ны “Орон тооны бус зөвлөл байгуулах тухай” а/265, “Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн зөвлөл байгуулах тухай” а/266 дугаар захирамжийг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА



А.ИШДОРЖ